

## **БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

**Нэр: Цус сэлбэлт судлалын үндэсний төв**

### **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвөөс 2021 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хүрсэн түвшинг тогтоон, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах, удирдлагыг бодит мэдээлэл, санал зөвлөмжөөр хангахад оршино.

### **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Эрүүл мэндийн байгууллагын 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Үнэлгээг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажил үүргийн хуваарийн дагуу харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн тайлан, яамны газар, хэлтсүүдээс гаргасан холбогдох мэдээ, мэдээлэл болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон өвөрмөц үзүүлэлтийн биелэлт, Хэрэглэгчийн үнэлгээний тайлангуудтай харьцуулалт хийх, тодруулга авах зэрэг үндсэн аргуудыг ашиглан гүйцэтгэсэн болно. Мөн тайлангын чанар, мэдээллийн бодит байдал, тайлан ирүүлэх хугацааг баримталсан байдал зэргийг үнэлгээний дүнд харгалзсан болно.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 үндсэн чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

1. Тухайн байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
3. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт, үүнд:
  - Үйл ажиллагааны ил тод байдал;
  - Хүний нөөцийн ил тод байдал;
  - Шилэн дансны хөтлөлт;
4. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт
5. Хэрэглэгчийн үнэлгээ

### Үнэлгээний нэгдсэн хүснэгт

|  | Үзүүлэлт  | Хувь                          | Оноо  |  |
|--|---|-------------------------------|-------|--|
| 1  | 2   | 3                             | 5     |  |
| Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ | 1. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт                                | 93,0                          | 4.4   |  |
|  | 2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт | 80,0                          |       |  |
|  | 3. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт                              | 90,9                          |       |  |
| Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ        | 4. Байгууллагын ил тод байдал   | Үйл ажиллагааны ил тод байдал | 91,4  |  |
|  |   | Хүний нөөцийн ил тод байдал   | 74,0  |  |
|  |   | Шилэн дансны хөтлөлт          | 100,0 |  |
| 5. Хэрэглэгчийн үнэлгээ                      |   |                               | 88,0  |  |
| Ерөнхий үнэлгээ:                             |   |                               | 88,7  |  |

**Нэг.** Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт: ЦССҮТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан

3.5 хүснэгтийн дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, тайлагнасан байна. Байгууллагын төлөвлөгөөнд 6 үндсэн зорилтын хүрээнд 59 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 2021 онд 93,0%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 0,18 байна.

**Хоёр.** Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт: ЦССҮТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.6 хүснэгтийн дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнасан байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 80,0%-ийн гүйцэтгэлтэй ба үнэлгээнд эзлэх хувийн жин 0,12 байна.

**Гурав.** Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт: ЦССҮТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.8 хүснэгтийн дагуу Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг тайлагнасан байна. Байгууллагын ирүүлсэн тайлан, Эрүүл мэндийн яамны холбогдох газар хэлтсийн мэдээ мэдээлэл болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон өвөрмөц үзүүлэлтийн биелэлтэд үндэслэн үнэлгээг гүйцэтгэсэн. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт 90,9%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 0,3 байна.

**Дөрөв.** Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт: ЦССҮТ нь Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын Хавсралтад тусгагдсан 3.7 хүснэгтийн дагуу байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийн тайланг шалгуур үзүүлэлтийн дагуу ирүүлсэн ба хэрэгжилт 88,5%-ийн гүйцэтгэлтэй, үнэлгээнд эзлэх хувийн жин 0,13 байна.

**Тав.** Хэрэглэгчийн үнэлгээ:

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 7.2 дахь хэсэгт Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг хийж ирүүлэх ба уг үнэлгээний дүнг байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглахаар заасан. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэглэгчийн үнэлгээний дүнгийн талаар эрүүл мэндийн байгууллагын удирдлага, бодлого боловсруулагч нарыг мэдээллээр хангах, эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг хангахад

дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино. Үнэлгээг амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасаг, нэгжүүдийн үйлчлүүлэгчээс энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон авч, агшингийн аргаар хийж гүйцэтгэсэн байна. Үнэлгээгээр хэрэглэгчийн сэтгэл ханамж 88%-тай үнэлэгдсэн байна.

### **Дөрөв. Санал, зөвлөмж**

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2021 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилт 88,7%-ийн гүйцэтгэлтэй буюу 4,4 оноотойгоор “В” үнэлэгдэв. Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт, ил тод байдал 90-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй буюу хэрэгжилт бүрэн хангагдсан байна. Ахxaарах асуудлууд:

- Эрүүл мэндийн сайдын 2021 оныс A/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.9-ын дагуу Эрүүл мэндийн байгууллагууд дотооддоо жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний танилцуулга, дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг ирүүлж байх
- Байгууллагын гүйцэтгэлийн тайланг Эрүүл мэндийн сайдын 2021 оныс A/605 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.5-3.8 дахь хавсралтад заасан бүх үзүүлэлтийг бүрэн тайлagnаж байх
- Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр мэдээллийн шинэчлэл, баяжилтыг тогтмол хийх
- Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**